

ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР

Огноо: **2019 оны 09 дүгээр сарын 16**

ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ АШИГЛАЖ ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ, ӨГӨГДӨЛ МЭДЭЭЛЛИЙН БАЯЖИЛТ ХИЙХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

**Орон зайн мэдээллийн систем ашиглаж инженерийн шугам
сүлжээний мэдээллийн сан үүсгэх, өгөгдөл мэдээллийн
баяжилт хийх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажил**

Төслийн дугаар:

ОСНААУГ-ШУТ-19/27

**Улаанбаатар
2019 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.09.16

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Орон зайн мэдээллийн систем ашиглаж инженерийн шугам сүлжээний мэдээллийн сан үүсгэх, өгөгдөл мэдээллийн баяжилт хийх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 10 цаг 30 минутаас** өмнө www.tender.gov.mn цахим системд ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 11 цаг 00 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй**
Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
Утас: 70111722

Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлгэдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- | | |
|--|--|
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулан ирүүлэх/</p> <p>3. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</p> <p>4. Сүүлийн 2 /2017, 2018 он/ жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт ирүүлэх</p> <p>5. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл: / 2017, 2018 онуудын аль нэг жилд ижил төстэй ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна. / Газарзүйн мэдээллийн сан, Веб ГМС хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан ижил төстэй төсөл амжилттай хэрэгжүүлсэн байх/ Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар Ажил хүлээлцсэн акт болон протоколын хуулбар</p> <p>6. Татварын тодорхойлолт ирүүлнэ. /Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.etch.mta.mn сайтаас авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай болон тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу татвар төлөлт, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн талаарх шаардлагатай мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг албан бичгээр ирүүлнэ.</p> <p>7. “Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн төлбөрийн үлдэгдэлгүй” тухай харилцагч банкны тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ.</p> <p>8. Ажлын даалгавар, шаардлагын дагуу санал болгосон үнээрээ, хугацаандаа чанартай хийж гүйцэтгэхийг баталсан албан бичиг ирүүлнэ.</p> <p>9. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх</p> <p>10. Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх</p> <p>11. НӨАТ төлөгч байх бөгөөд гэрчилгээний хуулбар ирүүлэх</p> <p>12. Баталгаат хугацаа 1 жил эсхүл түүнээс дээш жил байна. /Баталсан албан бичиг ирүүлнэ/</p> <p>13. Нийгмийн даатгалын тодорхойлолт ирүүлнэ.</p> <p>14. Инженер техникийн ажилнуудын ажлын туршлага танилцуулга, мэргэжлийн дипломны хуулбар ирүүлэх /Удирдах инженер нь Газар зүйн мэдээлэлийн системээр мэргэшсэн инженер байх ба ажлын даалгаварт тусгасан шаардлагын хангасан байх/</p> <p>15. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Шаардлагагүй</p>

ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</p> <p>Цахим хаяг: www.tender.gov.mn</p> <p>Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</p> <p>Цахим хаяг: www.tender.gov.mn</p> <p>Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

Дөрөв. АЖЛЫН ДААЛГАВАР

A. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

0.1 Захиалагч

Төслийн захиалагч Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар нь дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг:

- Улаанбаатар хотын оршин суугч хэрэглэгчдийг дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн усаар хангаж, бохир усыг татан зайлзуулах үйлчилгээг 24 цагийн турш тасралтгүй найдвартай үзүүлэх
- ОСНААУГ-ын салбар Түгээх төв, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангулан ажиллах
- Орон сууцны хороолол доторхи инженерийн шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

0.2 Захиалагчийн үйл ажиллагааны зорилго

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын эзэмшийн инженерийн шугам сүлжээний мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн санг газарзүйн мэдээллийн сантай холбон, орон зайн хайлт хийх боломжийг бүрдүүлэх зорилготой юм.

0.3 Нэр, томъёоны тайлбар

- Миррор холболт – Тооцоолон бodoх төхөөрөмжүүд өөр хоорондоо нэг ижил мэдээлэл байнга солилцон ажиллахаар холбогдоноыг;
- Сервисээр хангах – Систем хооронд өгөгдөл мэдээ солилцох;
- Давхаргуудаар хангах - Сервер болон ArcGIS десктоп програмаас Feature class буюу давхаргуудаар хангах;

Б. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШААРДЛАГА

1.1 Төслийн зорилго, зорилт

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын эзэмшийн инженерийн шугам сүлжээний мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн санг газарзүйн мэдээллийн сантай холбон, орон зайн хайлт хийх боломжийг бүрдүүлэх, Салбар байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, Улс нийслэлийн Газар зүйн мэдээллийн санггуудад мэдээ мэдээллээр хангах, цахим нэгдсэн мэдээллийг бүрдүүлэх зорилготой юм.

Хамрах хүрээ:

1. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын эзэмшийн инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт хамруулана.

Хийгдэх ажил:

1. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг газар зүйн мэдээллийн ArcGIS server 10.4 болон ArcGIS desktop 10.5 програм ашиглаж үүсгэх.
2. Улс нийслэлийн газар зүйн мэдээллийн санггуудтай холбох
3. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, ном гарын авлагаар хангах
 - А. Системийн ахсан түвшиний сургалт - 3 хүнд
 - Б. Байгууллагуудын мэдээлэл чуглуулах инженерүүдэд 2 удаагийн дунд түвшиний сургалт хийх – 48 хүнд

4. Дараах байгууллагуудын инженерийн шугам сүлжээний зураг, dwg, kmz, xls, zulu, jpg өргөтгөлтэй файлуудыг газар зүйн мэдээллийн сан үүсгэнэ.

1. Баруун түгээх төв
2. Төв түгээх төв
3. Зүүн түгээх төв
4. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-1
5. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-2
6. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-3
7. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-4
8. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-5
9. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-6
10. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-7
11. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-8
12. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-9
13. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-10
14. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-11
15. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-12
16. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-13
17. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-14
18. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-15
19. Хэрэглэгчдэд үйлчлэх төв-16

5. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын мэдээллийн санг Газарзүйн мэдээллийн сантай холбон, орон зайн хайлт хийх боломжтой Веб Гео мэдээллийн сан хөгжүүлж, хэрэглэгчийн мэдээллийн санг баяжуулах.

а. Бүрдэл: MS SQL database, Вэб ГМС хөгжүүлэлт, хэрэглэгчийн мэдээллийн санг ГМС-тай холбох

б. Техникийн үзүүлэлт: RDBMS Олон хэрэглэгч бүхий өгөгдөл мэдээ оруулах боломжтой мэдээллийн сан хөгжүүлэлт, ArcGIS server болон ArcGIS desktop сервис файлууд

в. Чанарын шалгуур: Бүрэн ажиллагаа бүхий Веб ГМС болон RDBMS мэдээллийн сан

Ажлын даалгавар

1	Төсөл боловсруулах үндэслэл	ОСНААУГ-ын инженерийн шугам сүлжээний нэгдсэн сан үүсгэх, нэгдсэн мэдээллийн системийн хөгжүүлэлт хийх
2	Төслийн ажлын зорилго	ОСНААУГ-ын Орон зайн мэдээллийн систем үүсгэх, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх
3	Төслийн хүрээнд боловсруулах эцсийн үр дүн	<p>ОСНААУГ-ын мэдээллийн санг Газарзүйн мэдээллийн сан (ГМС) -тай холбон, орон зайн хайлт хийх боломжтой Веб ГМС хөгжүүлж, хэрэглэгчийн мэдээллийн санг баяжуулах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• ГМС дээр суурилсан Веб аплийшн хөгжүүлэх• Хэрэглэгчийн мэдээллийн сангийн өгөгдлийг газарзүйн мэдээллийн сантай холбох, түүнийг орон зайн байршилаар харуулах• Эрх бүхий алба, хэлтэс хоорондын өгөгдөл мэдээ солилцох• Одоо байгаа системүүдээс зарим өгөгдөл, мэдээг Веб аплийшн дээр харуулах

4	Төслийг хэрэгжүүлэх аргачлал	<p>ОСНААУГ-ын мэдээллийн санг Газарзүйн мэдээллийн сантай холбон, орон зайн хайлт хийх боломжтой Веб ГМС хөгжүүлж, хэрэглэгчийн мэдээллийн санг баяжуулах зорилгоор дараах програм хангамжийн хөгжүүлэлтүүдийг хийнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ArcGIS server технологи ашиглан ГМС дээр суурисан веб апликешион хөгжүүлэх судалгааг хийх 2. Веб апликешион хийх бүтэц, загварыг гаргаж, батлуулах, үүнд суурь зураг, давхаргууд, таних тэмдэг, дэлгэц дээр харагдах элемент бүр дээр pop-up үүсгэх, хэрэглэгчийн мэдээллийн сан руу шилжих боломжтой байх, хайлтууд хийх, түүний үр дүнг харуулах боломжтой байх 3. Веб апликешины удирдлагын функц хөгжүүлэх, үүнд хэрэглэгчийн эрхийн түвшин үүсгэх, хэрэглэгч өгөгдөл мэдээг нэмэх, хасах боломжтой байх 4. Microsoft SQL server дээр алба, хэлтсүүдийн эрх бүхий мэргэжилтэнүүд хэрэглэгчийн мэдээг, ГМС –тай холбох боломж бүхий удирдлагын хэсгийг хөгжүүлэх 5. Хэрэглэгчийн мэдээллийг ГМС –тай дахин давтагдашгүй дугаар ашиглан холболт хийх 6. Веб ГМС дээр харуулах давхаргуудаас Web Feature Service, Web Map Service үүсгэх 7. Одоогийн хэрэглэж буй бусад өгөгдөл мэдээний сантай уялдуулах, зарим мэдээг Веб апликешион дээр харуулах 8. Гарын авлага, заавар боловсруулах
5	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Сонгон шалгаруулалтаар эрх авсан хуулийн этгээд
6	Төслийг хэрэгжүүлэх хугацаа: Эхлэх хугацаа Дуусах хугацаа	2019 оны IV-р улирал 2019 оны IV-р улирал
7	Төслийн хөрөнгийн хэмжээ	<p>Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоолоходоо дараах зүйлсийг багтаана . Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийслэлийн Дундын мэдээллийн сан болон бусад холбогдох мэдээллийн системүүдтэй хэрхэн уялдах тухай судалгаа 2. ОСНААУГ-ын одоо хэрэглэж буй бусад өгөгдлийн сан удирдах системүүдтэй хэрхэн уялдах, мэдээний бодит цаг хугацааны холболтыг хийх талаар судлах 3. Хөгжүүлэлтийн баг, түүний удирдлага менежментийн сарын цалин 4. ОСНААУГ-ын холбогдох мэргэжилтэнүүдийг сургах сургалт
8	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> • ОСНААУГ-ын Газарзүйн мэдээллийн сан дээр суурисан Веб апликешион хөгжүүлэлт, орон

		<p>зайн мэдээллийн санг онлайнаар удирдах, засварлах боломжтой веб хөгжүүлэлтийн ажил</p> <ul style="list-style-type: none"> • Орон зайн мэдээллийн санд эрх бүхий мэргэжилтэнүүд өдөр тутмын тогтмол мэдээ оруулах, мэдээ мэдээллийг шуурхай солилцох боломжтой удирдлагын програм хөгжүүлэлт • Сургалт • Програм хөгжүүлэлтийн ажил нь ArcGIS server, MS SQL server, Windows server –ийн орчинд ажиллах боломжтой програмчлалын орчин үеийн бүх төрлийн хэлийг ашиглаж болно.
9	Төсөл хэрэгжүүлэгчийн чадавхийн мэдээлэл	<ol style="list-style-type: none"> 1. Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд болох аж ахуйн нэгж байх. 2. Газарзүйн мэдээллийн сан, Веб ГМС хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай 3. Багийн ахлагч нь ГМС –ийн програм хангамжийн чиглэлээр ESRI –гийн бүтээгдэхүүнийг хэрэглэх туршлагатай, ESRI-гийн албан ёсны сургалтууд Building Geodatabase, Working with ArcGIS Network Analyst –ын сертификаттай бол давуу тал болно. 4. Багийн үндсэн гишүүдэд дараах шаардлагыг тавина. Үүнд: Програм хангамжийн ахлах инженер: ArcGIS Javascript API, PHP, JAVA мэдлэгтэй, MS SQL RDBMS, ES6, webpack, React JS, CSS3, Javascript ES5, ES6 зэрэг програм хангамжийн ажиллах туршлагатай. Програм хангамжийн инженер: ArcGIS javascript API, PHP, JAVA мэдлэгтэй, MS SQL or Oracle RDBMS, VUEjs, GIT туршлагатай
10	Тайлан	<p>Төсөл хэрэгжүүлэгч нь дараах байдлаар програм хөгжүүлэлтийн ажлыг холбогдох мэргэжилтэнүүд болон ажлын хэсгийн гишүүдэд тайлагнана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гэрээ байгуулагдсанаас хойш 1 сарын дараа: Веб applicейшны админ удирдлага, веб хөгжүүлэлтийн загвар, архитектур гаргаж батлуулах 2. Гэрээ байгуулагдсанаас хойш 3 сарын дараа: Веб applicейши хөгжүүлэлтийн дунд шатны тайлан, ГМС дээр боловсруулалтын ажил хийгдэж буй талаар тайлан гаргах 3. Гэрээ байгуулагдсанаас хойш 5 сарын дараа: - Эцсийн тайланг 2 хувь бичих -Ажил хүлээж авах зөвлөлд танилцуулга хийх -Хөгжүүлэлтийн код, програм хангамж, серверийн нөөцийг hard disk дээр хуулж өгч, акт үйлдэх

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| B. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэл заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлне. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоноо. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Орон зайн мэдээллийн систем ашиглаж инженерийн шугам сүлжээний мэдээллийн сан үүсгэх, өгөгдөл мэдээллийн баяжилт хийх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажил
ГЕН 3.1	Төслийн менежер нь : Захиалагч томилно.
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээ байгуулсан өдрөөс хуанлийн 30 хоногийн дотор
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жилийн байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5% байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10% байна.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн зургийг ажлыг хүлээлгэн өгснөөс хойш 14 өдрийн дотор гаргаж өгнө Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 200000 төгрөг байна.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “тэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;

- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
5.9. Санхүүжилтийн хуваарь;
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]